



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 7 сарын 05 өдөр

Дугаар 142

Улаанбаатар хот

### Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Констракшн коммершл инвестмент” ХХК-д банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.
2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, зохих өөрчлөлтийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Констракшн коммершл инвестмент” ХХК /Г.Туул/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН